



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/А37

Номгон

Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн
тоо бүртгэлийг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан "Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам"-ын 3.1, 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг 2021 оны 12 дугаар сарын 03-наас 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Агаарын бохирдлын эх үүсвэрийг нэгдсэн тооллогод хамруулж, бүртгэл хяналтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Э.Ганзориг -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүдэд:

С.Амармөнх (Баянхонгор аймгийн Авто тээврийн төвийн дарга)

С.Рэнцэндагва (Татварын хэлтсийн дарга)

Н. Энхжаргал (Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ж.Алтангэрэл (Онцгой байдлын газрын дарга, Хурандаа)

А.Батхуяг (Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, Хошууч)

Э.Сэмбэсүрэн (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал, газрын харилцаа, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн)

Г.Бямбасүрэн (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн)

2.

Д.Бат-Эрдэнэ (Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Б.Бадамцэцэг ("Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-ний ерөнхий инженер)

Сумдын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга Ч.Оюунчимэг (Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга)

3.Агаарын бохирдлын суурин эх үүсвэрийн бүртгэл тооллого явуулах журмыг мөрдөж, дүнг нэгтгэн боловсруулж, явцын мэдээг ажлын 14 хоног тутамд Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлж, дүн мэдээг эцсийн байдлаар 2022 оны 01 дүгээр сарын 16-ны дотор багтаан гаргаж аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж, 2022 оны 01 дүгээр сарын 20-ны дотор Цаг уур, орчны шинжилгээний газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсэг (Э.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН